

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5.1.6-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан хөтлөхтэй холбогдсон” журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд (Г.Ёндон), Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд), Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян), Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан тэсэлгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн шинэчилсэн бүртгэл хийхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

Г.ЁНДОН

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ХӨТЛӨХТЭЙ ХОЛБОГДСОН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын хэмжээнд үйлдвэрлэлийн зориулалттай хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, байршил /цаашид “эргэлт” гэх/, тэсрэх материалтай харьцах ажилтан, тэсэлгээчин, пиротехникийн хэрэгсэлтэй харьцах мэргэжилтний бүртгэл, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийн санг /цаашид “мэдээллийн сан” гэх/ тайлагнах, мэдээлэх, хөтлөхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эд, пиротехникийн хэрэгслийг импортлох тоо хэмжээг заасан зөвшөөрөл, тээвэрлэлтийн зөвшөөрөл зэргийг олгох, тэсрэх материалын хяналтын хуудас, тээвэрлэлтийн хуудас, үйлдвэрлэсэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлд сери дугаар олгох ажлыг тус тус зохион байгуулах, оролцогч байгууллагуудын харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

2.1. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэгдсэн систем” гэж Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийг агуулсан сан, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл, тэсрэх материалын хяналтын хуудас, тээвэрлэлтийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн хуудас, үйлдвэрлэсэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлд сери дугаар, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эд, пиротехникийн хэрэгслийг импортлох тоо хэмжээг заасан зөвшөөрлүүдийг олгох ажлыг цахимаар зохион байгуулах зориулалттай цогц системийг;

2.2. “Нэгдсэн мэдээллийн сан” гэж Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан харилцааг, түүнчлэн хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл, тэсрэх материалын хяналтын хуудас, тээвэрлэлтийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн хуудас, үйлдвэрлэсэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлд сери дугаар, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эд, пиротехникийн хэрэгслийг импортлох тоо хэмжээг заасан зөвшөөрлүүдийн мэдээллийг агуулсан санг;

2.2.1. “Хуулийн этгээдийн дэд сан” гэж тэсэлгээний ажил явуулах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд,

мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын үндсэн мэдээлэл, бусад холбогдох бичиг баримтуудыг багтаасан санг;

2.2.2. “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн дэд сан” гэж хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан (туршсан) тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, байршлыг тусгасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн тайлан, мэдээг аж ахуйн нэгжүүдээс цахим систем ашиглан хүлээн авч нэгтгэх, статистик мэдээ гаргах, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах, улсын хилээр нэвтрүүлж байгаа тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эд, пиротехникийн хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийн бүртгэлийг хөтлөх санг;

2.2.3. “Мэргэжлийн боловсон хүчний дэд сан” гэж тэсэлгээчний болон харьцах эрхийн үнэмлэх олгох сургалтад хамрагдсан хүмүүсийн бүртгэл, үнэмлэхтэй ажиллагсадын шилжилт, хөдөлгөөн, амь насны даатгал, шинжээчдийн бүртгэл, бусад холбогдох мэдээллүүдийг багтаасан санг;

2.2.4. “Тэсрэх материалын үйлдвэр, агуулах, тэсэлгээний зориулалттай тоног төхөөрөмжийн дэд сан” гэж тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, тэсрэх материалын агуулах, тэсэлгээний зориулалттай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, лабораторийн мэдээллийг багтаасан санг;

2.3. “Эргэлтийн тайлан” гэж хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан (туршсан) тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, байршлыг тусгасан улирал тутамд ирүүлэх цахим тайланг;

2.4. “Хуулийн этгээд” гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4.1.8, 11, 12, 13, 15, 16, 17 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг;

Гурав. Мэдээллийн сангийн бүтэц, зохион байгуулалт

3.1. Энэхүү журмын 2.2-т заасан мэдээллийн сан нь дараах дэд сангуудаас бүрдэнэ.

3.1.1. Хуулийн этгээдийн

3.1.2. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн

3.1.3. Мэргэжлийн боловсон хүчний

3.1.4. Тэсрэх материалын үйлдвэр, агуулах, тэсэлгээний зориулалттай тоног төхөөрөмжийн

3.2. Энэхүү журмын 3.1-д заасан дэд сангууд холбогдох чиг үүргийн байгууллагууд дээр байж болно.

3.3. Энэхүү журмын 3.1.1-д заасан мэдээллийг хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл авснаас ажлын 5 хоногт багтаан мэдээллийн санд бүртгүүлэх үүрэгтэй.

3.4. Хуулийн этгээд нь энэхүү журмын 2.3-т заасан эргэлтийн тайланг улирал тутамд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн санд зөвхөн цахимаар ирүүлнэ.

3.5. Энэхүү журмын 3.1.3-т заасан санг мэргэжлийн хяналтын байгууллага, сургалтын байгууллагууд хамтран хөтөлж, Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн санд тухай бүр ирүүлнэ.

3.6. Энэхүү журмын 3.1.4-т заасан мэдээллийг хуулийн этгээд нь аюулгүйн бүс тогтоосон акт, ашиглалтад хүлээн авсан шийдвэрийг тухай бүр мэдээллийн санд бүртгүүлнэ.

3.7. Энэхүү журмын 3.1.1-3.1.4-т заасан санг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллага, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, цагдаагийн болон тагнуулын байгууллага, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, сургалтын байгууллагууд ашиглана.

Дөрөв. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэгдсэн систем”-ийн бүтэц, зохион байгуулалт

4.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан нэгдсэн системээр дамжуулан холбогдох хууль, журамд заасан шаардлагын дагуу дараах үйлчилгээг хуулийн этгээдэд үзүүлнэ.

4.1.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4.1.8-д заасан эрх, мөн хуулийн 11, 12, 13, 15, 16, 17 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгох;

4.1.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эд, пиротехникийн хэрэгслийг импортлох тоо хэмжээг заасан зөвшөөрөл олгох, сунгах;

4.1.3. Үйлдвэрлэсэн тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлд сери дугаар олгох;

4.1.4. Салбарын статистик мэдээллийг төрийн холбогдох байгууллага, мэргэжлийн холбоод, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн хүргүүлэх;

4.2. Мэргэжлийн хяналтын төв байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан нэгдсэн системээр дамжуулан холбогдох хууль, журамд заасан шаардлагын дагуу дараах үйлчилгээг хуулийн этгээдэд үзүүлж, энэхүү журмын 2.2-д заасан мэдээллийн санд бүртгүүлнэ.

4.2.1. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөө болон холбогдох бичиг баримтад үндэслэн тэсрэх материалын хяналтын хуудсыг олгож, ажлын 5 хоногийн дотор бүртгүүлэх;

4.2.2. Цагдаагийн байгууллагаас олгосон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх зөвшөөрлийг үндэслэн тэсрэх материал тээвэрлэх хуудсыг олгож, ажлын 5 хоногийн дотор бүртгүүлэх;

4.2.3.

4.3. Цагдаагийн байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан нэгдсэн системээр дамжуулан холбогдох хууль, журамд заасан шаардлагын дагуу дараах үйлчилгээг үзүүлнэ.

4.3.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх зөвшөөрлийг олгох;

4.3.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлттэй холбоотой гарсан гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээллийг тухай бүрт мэдээллийн санд бүртгүүлэх;

4.4. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь устгасан тэсрэх материалын тайланг гаргаж, мэдээллийн санд ажлын 5 хоногийн дотор бүртгүүлнэ.

Тав. Хуулийн этгээдийн эрх, үүрэг

5.1. Хуулийн этгээд нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

5.1.1. Мэдээллийн сангаас салбарын статистик мэдээллийг зохих эрхийн дагуу хүсэлт гаргасны үндсэн дээр авч байх;

5.1.2. Энэхүү журмын 4.1.- 4.3 хүртэлх үйлчилгээг нэгдсэн мэдээллийн сангаар дамжуулан холбогдох хууль, журамд заасан шаардлагын дагуу авах;

5.1.3. Мэдээллийн санд шаардлагатай мэдээлэл, холбогдох бичиг баримтыг энэхүү журамд заасан хугацаанд үнэн, бодитой материал ирүүлэх;

5.1.4. Энэхүү журмын 3.4-т заасан тайланг дараа улирлын эхний 10 хоногт багтаан ирүүлэх;

5.1.5. Хуулийн этгээдийн үндсэн мэдээлэлд өөрчлөлт орох өөрчлөлтийг Төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авч өөрчилнө.

Зургаа. Бусад

6.1. Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхөөс бусад, нууцад хамаарахаас бусад мэдээллийг нээлттэй мэдээлнэ. Хувьд ашиглахыг болон өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

6.2. Цаг үеийн холбоотой зарлал, мэдээллийг тухай бүрт хүргэдэг байх.

6.3. Үнэн зөв, бодитой мэдээлэл ирүүлэх.

Зургаа. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

7.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх журмыг зөрчсөн, эсхүл хуурамч бичиг баримт бүрдүүлэн зөвшөөрөл авсан тохиолдолд байгууллага, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Хуулийн этгээд нь эргэлтийн тайланг буруу мэдээлбэл хариуцлага хүлээнэ.

----o0o----